



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХХҮ1.1.ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2022 онд Улсын төсөв болон ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн тухай.

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 307 дугаар тогтоолоор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөв болон Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хэмжээг тус тус тогтоосон.

Тус тогтоолын хэрэгжилт 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгаар 46,1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 24,4 тэрбум төгрөгийг төвлөрүүлж хэрэгжилт 52,9 хувьтай, Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгаар 535,5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 133,8 тэрбум төгрөгийг төвлөрүүлж хэрэгжилт 24,9 хувьтай хангалтгүй байгааг тэмдэглээд.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

“Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Ирээдүй өв санд төвлөрүүлэх ногдол ашиг 24,224,150.0 мянган төгрөг, “Багануур” ХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг 556,310.0 мянган төгрөгийг чөлөөлөх боломжгүй тул хуулийн хугацаанд төвлөрүүлэх арга хэмжээ авахыг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгох, Улсын төсөв болон ирээдүйн өв санд төвлөрүүлэх ногдол ашгийг төвлөрүүлээгүй болон дутуу төвлөрүүлсэн “Эрдэнэ үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ, “Ховдын дулааны станц” ТӨХК, “Монгол шуудан” ХК, “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын захирал, гүйцэтгэх захирал нарт хугацаатай үүрэг өгч, ногдол ашиг төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 307 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгов” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

132002415

26-r_huraldaan.docx